

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН БИЕЛЭЛТ

2017.06.21

Говьсүмбэр аймаг

д/д	ЗГҮАХ-т тусгагдсан, зорилт	Арга хэмжээний дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)		Хэрэгжилтийн хувь
							2017		
							Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	
0	1	2	3	4	5	6	7	8	9
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО									
Тэргүүлэх зорилт №2.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор “ЭРҮҮЛ ХҮНС-ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” үндэсний хөтөлбөр, “ҮЙЛДВЭРЖИЛТИЙН 21:100” хөтөлбөр, “ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ” хөтөлбөр, “МАХ, СҮҮНИЙ АНХДУГААР АЯН”-ыг шинээр эхлүүлж, “АТРЫН-III АЯН”-ыг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.									
1	2.23 Иргэдийн эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж, хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын тогтолцоог бий болгож, хүнсний аюулгүй байдлыг сайжруулна.	6	Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх суурь судалгаа хийх, журам боловсруулах, сургалт зохион байгуулах	2017-2018	АЗДТГ		Журмын төсөл боловсруулж, тооцоо судалгаа хийх	Стратегийн хүнсний улирлын нөөцийн судалгааг хийсэн. Судалгаагаар аймгийн нийт хүн амд 235,1 тн мах, 176,3 тн сүү, 2350 тн ус, 117,5 тн гурил шаардлагатайг тодорхойлсон. Стратегийн хүнсний хэрэгцээг хүнсний томоохон дэлгүүр агуулахаас уламжлалт аргаар бэлтгэсэн махны 23 хувь, сүүний 0.02 хувь, гурилны 58 хувь, цэвэр усны 0.23 хувийг бүрдүүлэх боломжтой байна.	40
2	2.25. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх,	1	“Төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах	2016-2020	АЗДТГ		“Монгол мал” үндэсний хөтөлбөрийн	“Монгол мал” хөтөлбөрийн 2017-2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 15 зорилт 62 арга	40

	эдийн засгийн эргэлтийг сайжруулах, дэвшилтэт техник, технологийн шинэчлэлийг хийх, инновацийг нэвтрүүлэх, түүнчлэн “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.		бодлого”-ын эхний үе шатны төлөвлөгөө, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хоёр дахь үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх, хэрэгжүүлэх				хоёр дахь үе шатны үйл ажиллагааны болон “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын төлөвлөгөөний хэрэгжилтийг 20 хувьд хүргэх	хэмжээтэйгээр батлуулан, хагас жилийн байдлаар хэрэгжилт 42 хувьтай байна. Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 2017-2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө хагас жилийн байдлаар 30.7 хувьтай хэрэгжсэн байна.	
		2	Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл болон малын тэжээл, хадлан бэлтгэлд техник, технологийн шинэчлэл, инновацийг нэвтрүүлэх, лизингийн үйлчилгээг хөгжүүлэх	2016-2020	АЗДТГ		МАА-н үйлдвэрлэлийн техникийн шинэчлэлийг 5-аас доошгүй хувиар, дэвшилтэт технологи, инновацийн бүтээгдэхүүн нэвтрүүлэлтийг 3 хувиар нэмэгдүүлэх	Аймгийн нутаг дэвсгэрт жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг аймгийн Засаг даргын 2017 оны А/149 дүгээр захирамжаар батлуулсан. Тус тэргүүлэх чиглэлд мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар тусгасан. Мал нядалгааны цех байгуулах санал санаачлага гаргасан 2 иргэн, 1 ААН-ийг эрчимжсэн мал аж ахуйн бүсэд газар олгон, төсөл, хөтөлбөрийн зээлд хамруулахаар төлөвлөн ажиллаж байна. Шивээговь суманд мал нядалгааны 1 цэг үйл ажиллагаа явуулж байна.	40
3	2.26. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол малчин”, “Малжуулах”	2	“Монгол малчин” хөтөлбөрийг боловсруулж,	2017-2020	АЗДТГ		“Монгол малчин” хөтөлбөрийг боловсруулж,	“Монгол малчин” хөтөлбөр батлагдаагүй тул хэрэгжүүлэх хугацаа болоогүй.	ҮБ

	хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.		хэрэгжилтийг зохион байгуулах				хэрэгжүүлж эхлэх		
		3	“Малжуулах” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх	2017-2020	АЗДТГ		5000 мал худалдан авахад дэмжлэг үзүүлэх	Малжуулах төсөл хөтөлбөрт 27.0 сая төгрөг батлагдсан. Үүний хүрээнд 5 малчин өрхөд 25.0 сая төгрөг бүхий мал худалдан авч дэмжлэг үзүүлж, 2.0 сая төгрөгөөр 16 малчинд мал аж ахуйн талаар сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн. Хагас жилийн байдлаар Сүмбэр сумаас 6, Шивээговь сумаас 3, Баянтал сумаас 3 малчны төсөл нийт 12 төсөл ирээд байна. Төслийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдсан. Малжуулах хөтөлбөрийн хүрээнд Сүмбэр сум 10 өрхөд 300 бог мал 8 сард, Шивээговь сум 4 өрхөд 224 бог мал 10 сард олгохоор төлөвлөсөн.	40
4	2.30. Малыг бүртгэлжүүлж, малын гаралтай түүхий эд бэлтгэлийн чанар стандартыг дээшлүүлж, гарал үүслийг тодорхой болгох системийг бүрдүүлнэ.	2	Малын гаралтай түүхий эдийн стандартуудыг шинэчлэх, мөрдүүлэх, түүхий эдийн чанарыг орон нутагт хянан баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлэх, тоног төхөөрөмжийн	2017-2020	АЗДТГ		Малын гаралтай түүхий эдийн стандартуудыг шинэчлэн батлах	Малын гаралтай түүхий эдийн стандарт шинэчлэн батлагдаагүй тул орон нутагт хэрэгжүүлж эхлээгүй байна. Хугацаа болоогүй	ҮБ

			дэмжлэгийг сумдад үзүүлэх						
5	2.34. Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулах үйл ажиллагаанд зээлийн дэмжлэг үзүүлж, өвс тэжээлийн аюулгүй нөөцийг нэмэгдүүлнэ.	2	Өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх техник, тоног төхөөрөмжийг сайжруулж, өвс, тэжээлийн агуулахыг орон нутагт бий болгох		АЗДТГ		Өвс, тэжээлийн нөөцийн агуулахгүй сумдын байршлыг харгалзан шинээр 5 агуулах барих	Аймгийн хэмжээнд өвс тэжээлийн 310 тн-ын багтаамжтай 6 агуулах байна. Эдгээр агуулахууд нь Сүмбэр сумын 4, 5-р баг, Шивээговь сум, Баянтал суманд тус бүр 1, Сүмбэр сумын 6-р багт 2 агуулах байна.	70
6	2.35. Хөдөөгийн хүн ам болон мал аж ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээрт худаг, хөв цөөрөм барьж байгуулан ашиглалт, хяналтыг сайжруулна.	1	Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор инженерийн хийцтэй болон энгийн уурхайн худаг гаргах, цас, борооны ус тогтоох хөв цөөрөм барьж байгуулах		АЗДТГ		Шинээр 250 худаг, 1-ээс доошгүй хөв, цөөрөм барьж байгуулснаар нийт мал сүргийн усан хангамж 10 орчим хувиар нэмэгдэх	2017 онд Улсын төвийн хөрөнгө оруулалтаар бэлчээрт 3 инженерийн хийцтэй худаг гаргахаар шийдвэрлэгдсэн.	40
		2	Нар, салхины сэргээгдэх эрчим хүчийг ашиглан газрын гүнээс ус татах тоног төхөөрөмжийг хуучин инженерийн хийцтэй худгуудыг засварлан суурилуулах, худаг гаргах үйл	2017-2020	АЗДТГ		Инженерийн хийцтэй 25-аас доошгүй худагт нар, салхины эрчим хүчээр ажиллах ус өргүүр суурилуулах	Аймгийн хэмжээнд салхины эрчим хүчээр ажилладаг ус өргүүр суурилуулан, тохижуулсан 5 худаг байна. 2017 оны хагас жилийн байдлаар шинээр инженерийн хийцтэй худагт нар, салхины эрчим хүчээр ажиллах ус өргүүр суурилуулах ажил хийгдээгүй.	40

			ажиллагаанд шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх						
7	2.39. Эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бүс нутгийг тогтоон үр тариа, төмс, гол нэрийн хүнсний ногоог 100 хувь, таримал тэжээлийн 50 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангана.	7	Газар тариалангийн механикжсан ажлыг төлбөртэй гүйцэтгэж өгдөг аж ахуйн нэгж, хоршоонд техник, технологийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх, төмс хүнсний ногоо үйлдвэрлэлийн техникийн шинэчлэл хийх	-	АЗДТГ	-	Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлд шаардлагатай дунд оврын трактор, ХАА-н машин нийлүүлж, эргэн төлөх нөхцөлтэйгээр ногоочдод олгох	Аймгийн хэмжээнд 2 цэгт техникийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд одоогийн байдлаар нийт 2 га талбайн хөрс боловсруулахад техникийн үйлчилгээ үзүүлээд байна. Бага оврын 6, дунд оврын 2, том оврын 1, нийт 9 трактор техникийн үйлчилгээ үзүүлж байна.	40
8	2.40. Жимс жимсгэний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, чацарганы үйлдвэрлэлийн нэгдсэн сүлжээ байгуулан, хүн амыг амин дэм бүхий жимс жимсгэнээр ханган, экспортын орлогыг нэмэгдүүлнэ.	1	"Жимс жимсгэнэ" хөтөлбөр хэрэгжүүлж, Монголд ургах боломжтой жимс жимсгэний сортуудыг турших, нутагшуулах, үржүүлэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, чацарганы тариалалт, хураалт, хадгалалт, боловсруулалт, борлуулалтын	2016-2020	АЗДТГ		НҮБ-ын ХХААБ-аас "Жимс жимсгэнэ" төсөл хэрэгжүүлж, алим, чавганы суулгац импортолж туршиж эхлэх, жимс жимсгэний тариалалтыг 6500 га-д хүргэх, ургац	Хөдөө аж ахуйн их сургуультай хамтран жимс жимсгэний мод бут тариалах сонирхолтой иргэдэд сургалт зохион байгуулж 52 иргэн хамрагдсан. Жимс жимсгэнэ тариалдаг 3 иргэний талбайд таналт, тайралтын талаар дадлага сургууль хийсэн. Мөн 5 иргэн 0.21 га талбайд 225 ш чацарганы мод тарьсан. Нийт 0.26 га талбайд чацаргана, жимс жимсгэнэ тариалсан.	40

			чанар стандарт, судалгаа шинжилгээнд суурилсан сүлжээг үүсгэж, өрсөлдөх чадварыг сайжруулан "Монгол чацаргана" бренд бий болгох, экспортод тогтвортой гаргах				4000 тонн-д хүргэх		
9	2.43. Усны хайгуул, судалгаанд үндэслэн услалтын систем шинээр барьж, сэргээн засварлах, усалгааны дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхийг дэмжиж, усалгаатай талбайн хэмжээг жил бүр нэмэгдүүлнэ.	1	Хайгуул судалгаа хийгдсэн бүсүүд болон томоохон голуудын сав газарт урсацын тохируулга хийж, ус хуримтлуулах усан сан бүхий томоохон услалтын системийн толгойн барилга, усыг талбайд хүргэх гол суваг (хоолой), талбай хоорондын ус хуваарилах сүлжээний барилга байгууламжийг барих	2016-2020	АЗДТГ		Усалгаатай тариалангийн хэмжээг 1.0 мянган га-аар нэмэгдүүлэх	Баянтал суманд тэжээлийн ургамал тариалах зориулалтаар усалгаатай талбайн хэмжээ 2 га-газар нэмэгдэж, талбайг хашаажуулан царгас тариалсан. Аймгийн хэмжээнд усалгаатай талбай 76.5 га талбайд хүрсэн.	40
10	2.44. Өвөл, зуны хүлэмжийн загвар, цогцолбор аж ахуйг хөгжүүлж, хот суурингийн хүн амыг	1	Өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулахад урт хугацаатай зээлийн эх үүсвэр бий	2016-2020	АЗДТГ		Хүлэмжийн талбайг 10 га-газар, ургацыг 3000 тн-оор нэмэгдүүлэх	Шинээр хүлэмжийн аж ахуй эрхлэх сонирхолтой 3 иргэнийг арга зүйн зөвлөгөөгөөр хангасан бөгөөд 2017 оны 06 дугаар сарын 14-ний	40

	шинэ ургацын ногоогоор тогтвортой хангана.		болгох, томоохон хот суурин газруудад гадаад орон, олон улсын байгууллагын санхүүжилтээр загвар, цогцолбор аж ахуйнуудыг байгуулах, зуны хүлэмжийн аж ахуйн хангамжийг сайжруулж, орон нутагт хөнгөлөлттэй үнэ, нөхцөлөөр нэвтрүүлэх				байдлаар 1186 м ² талбай бүхий 29 хүлэмжинд 4 төрлийн ногоо тариалсан байна.	
11	2.48.Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлж, импортыг орлох экспортын чиглэлийн тэргүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ.	6	"Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг боловсруулан батлуулах	2016-2020	АЗДТГ	Өнөөгийн байдлын судалгаа хийж, аж үйлдвэрийн зураглал гаргах, хөтөлбөрийн төслийг боловсруулж батлуулах	Үйлдвэрийн дэлгэрэнгүй судалгаанд 24 үйлдвэрийг хамруулан сан үүсгэж холбогдох газарт хүргүүлсэн. 3 сумын жижиг дунд 15 үйлдвэрлэл эрхлэгчдийн ажил байдалтай танилцан арга зүйн зөвлөгөө өгсөн.	40
		7	"Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 21 аймагт 100 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэр	2016-2020	АЗДТГ	Нөхцөл байдлын судалгаанд үндэслэн үйлдвэржилт ийн зураглал гаргаж, аймаг, орон нутгийн	Орон нутагт байгуулах шаардлагатай байгаа жижиг дунд үйлдвэрийн судалгааг анхан шатны байдлаар гаргасан бөгөөд махны 1, сүүний 1, арьс боловсруулах 1 жижиг үйлдвэр байгуулах саналыг холбогдох газарт хүргүүлсэн.	ҮБ

			байгуулахад санхүү, эрх зүйн дэмжлэг үзүүлж ажиллах				нөөц боломжид тулгуурласан үйлдвэрүүдийн ТЭЗҮ-ийг боловсруулах		
		10	Ахуй үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	2017-2020	АЗДТГ		Хөтөлбөрийг боловсруулах судалгаа, уулзалт хэлэлцүүлгүүд хийгдэх, хөтөлбөрийг боловсруулах	Ахуй үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр батлагдаагүй тул хэрэгжүүлэх хугацаа болоогүй.	ҮБ
Тэргүүлэх зорилт №2.4. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, байгаль орчин, хүний эрүүл мэндийн шаардлагад нийцсэн барилгын үйлдвэрлэлийг дэмжиж, аюулгүй, хүртээмжтэй орон сууцаар хангах төрийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлнэ.									
12	2.77. Хүн амын орон сууцны хэрэгцээг хангах зорилгоор нэгдсэн бодлого боловсруулж, "Хямд өртөгтэй орон сууц" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	1	"Орон сууц" үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	2016-2020	АЗДТГ		Холбогдох судалгааг хийх	"Орон сууц" үндэсний хөтөлбөр батлагдаагүй.	ҮБ
		3	Аймаг бүрт "1000 айлын орон сууц" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2016-2020	АЗДТГ		6 аймагт 1000 айлын орон сууц барих ажлыг зохион байгуулах	1000 айлын орон сууцны дэд бүтцийг шийдвэрлэх хөрөнгө санхүүжилт шийвэрлэгдээгүй тул зохион байгуулсан ажил байхгүй байна.	ҮБ
13	2.86. Хот, суурин газруудад шинээр баригдах орон сууцны хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээний техникийн	1	Аймгийн төвүүдийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг	2016-2018	АЗДТГ		Аймаг бүрт 1000 айлын орон сууц төсөл хэрэгжих	1000 айлын орон сууц төсөл хэрэгжүүлэхээр 2016 онд гадна инженерийн шугам сүлжээний зураг төсвийг хийлгэсэн. Шугам сүлжээний ажлын төсөв	ҮБ

	шийдлийг хонгилын системээр төлөвлөн, үе шаттай хэрэгжүүлнэ.		үргэлжлүүлэн хэрэгжүүлэх				нөхцөл бүрдэх	шийдвэрлэгдээгүй тул хийгдээгүй байна.	
		3	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний насжилтийг уртасгах, шинэчлэх, засварлах ажилд шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх	2016-2020	АЗДТГ		Шуудуугүй технологийн аргаар сэргээн засварлах төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах	Шуудуугүй технологийн аргаар сэргээн засварлах төсөл хэрэгжүүлж эхлээгүй байна. Хугацаа болоогүй.	ҮБ
14	2.88. Хот, суурин газруудын газар хөдлөлтийн үйлчлэлийн давтамж, эрчмийг шинэчлэн тогтоож, барилга байгууламжийн төлөвлөлтөд тусгах, ашиглагдаж байгаа барилга байгууламжуудын бат бэх, найдвартай байдлыг сайжруулах арга хэмжээг төлөвлөж, үе шаттай хэрэгжүүлнэ.	3	Барилга байгууламжийг паспортжуулах ажлыг хэрэгжүүлэх	2016-2020	АЗДТГ		Барилга байгууламжийг паспортжуулах ажлыг аймгуудад шинээр, нийслэлд үргэлжлүүлэн хийх /203 барилга/	Барилга байгууламжийг паспортжуулах ажлын дүрэм, журам батлагдаагүй тул хэрэгжүүлэх хугацаа болоогүй байна.	ҮБ
		4	Газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгын судалгааг гаргаж, тэдгээрийг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах	2016-2020	АЗДТГ		Аймаг, нийслэл дэх газар хөдлөлтөд тэсвэргүй барилга байгууламжийн судалгааг хийж, инженерийн дүгнэлт,	Сүмбэр сумын 3-р багийн нийтийн зориулалттай газар хөдлөлтөд тэсвэргүй барилга байгууламжид инженерийн дүгнэлт гаргуулах ажлыг гүйцэтгүүлэх хөрөнгийг 2017 оны төсвийн тодотголоор АОНХСанд тусган батлуулсан. 2018 онд төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын зураг төсөв боловсруулах зардлын	40

						төсөв, санхүүгийн тооцоог мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	хөрөнгөөр гүйцэтгэхээр төлөвлөж байна.	
	5	Газар хөдлөлтийн лаборатори байгуулах, техник, тоног төхөөрөмж нийлүүлэх, хүний нөөцийг сургаж бэлтгэх ажлыг зохион байгуулах	2017-2020	АЗДТГ		Газар хөдлөлтийн үйлчлэлд барилга байгууламжийг тооцох, төлөвлөхтэй холбоотой хийц, элементийн бат бэх, тогтворыг турших лаборатори байгуулагдаж, барилга, байгууламжийн чанар, аюулгүй байдал сайжрах, хүн амын аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөл бүрдэх	БХБС-ын 2006 оны 120 дугаар тушаалаар батлагдсан “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм” БНБД22.01-01*/2006-ын дагуу “Чойр хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-нд газар хөдлөлтийн 6 баллд тэсвэртэй байхаар барилга байгууламжийг төлөвлөж, төлөвлөгөөний дагуу бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж байна. Мөн Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар аймгийн “Бичил мужлалын зураг” зохиох ажил хийгдэж байна. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дэргэдэх барилгын материалын лабораторид Барилга хот байгуулалтын яамнаас автомат шигшүүр /0,008-0,05/, асгаас тодорхойлох цилиндр хувин /90, 180, 200 мм/, Штанген циркуль /ф300 мм дижитал/, электрон жин /1гр-30кг нарийвчлалтай/, хатаах зуух /1100 градус/, усан ванн, пресс	40

								<p>/2000 KN/, сорьцын хэв төмөр /70x70x70,100x100x100,150x150x150/, Шмитын алх гэсэн бетон дүүргэгч, керамик материал, бетоны марк тодорхойлох нийт 9 төрлийн чанарын лабораторийн тоног төхөөрөмжөөр хангасан. Тус лаборатори нь байр байхгүйгээс шалтгаалан үйл ажиллагаа явуулахгүй байна. Иймд 2017 онд захиалагчийн хяналтын зардлаар байрны асуудлыг шийдвэрлэхээр төлөвлөн, зураг төсвийг хийлгэж байна.</p>	
15	<p>2.93. Утасгүй интернетийн хүртээмжийг нэмэгдүүлж, амралт, зугаалгын бүс, номын санд ашиглах боломжийг бүрдүүлнэ.</p>	1	<p>Хөдөө орон нутгийн интернетийн үйлчилгээ хүрээгүй сумд, стратегийн болон аялал жуулчлалын бүс нутаг, хүн ам ихээр төвлөрдөг газарт утасгүй интернетийн үйлчилгээг хүргэх</p>		АЗДТГ		<p>Интернэтийн үйлчилгээ хүрээгүй 30 сум, суурин газарт утасгүй интернетийн үйлчилгээ хүрэх, иргэдийн интернэт болон мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээ, хүртээмж нэмэгдэх</p>	<p>Баянтал суманд хувийн хөрөнгө оруулалтаар интернетийн үйлчилгээг оруулаад байна. Аймгийн хэмжээнд Unitel компани утасгүй интернетийн үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд хагас жилийн байдлаар 250 орчим өрх утасгүй интернетийн үйлчилгээ авсан байна.</p>	100
<p>ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГО</p>									

Тэргүүлэх зорилт №3.1. Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг боловсруулж, хүн амыг аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх эдийн засгийн тооцооллыг бий болгож, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлнэ. Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, дадал, хандлагад төлөвшүүлж нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн тусламж үйлчилгээг эрс сайжруулах, Халдварт бус өвчнөөс сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого төлөвлөлтөд урт болон дунд хугацааны хөтөлбөр боловсруулж, чанар хүртээмжийг дээшлүүлнэ. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг хангаж, нийгмийн хамгааллыг сайжруулна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанартай уялдсан эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгоно.

16	3.1.3. Элэгний хорт хавдар, хатуурлын нас баралтыг эрс бууруулах, элэгний С вирусын голомтыг 2020 он гэхэд устгаж, халдварт тархалтыг таслан зогсоох, “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр хэрэгжүүлнэ.	3	Элэгний вирус халдвар, элэгний хатуурлыг оношлох багаж, хэрэгслээр аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдийг үе шаттайгаар хангах		АЗДТГ	-	-	Засгийн газрын 2017 оны 04 дүгээр сарын 12-ны 112 дугаар тогтоол “Элэг бүтэн монгол үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 40-65 насны гепатитийн В,С вирус эрт илрүүлэг, үзлэг шинжилгээнд 3906 иргэнийг хамруулахаар төлөвлөн ажиллаж байна. В,С вирус эрт илрүүлгийн санхүүжилт 2-р улиралд шийдвэрлэгдсэнтэй холбогдуулан 2017 оны 05 дугаар сараас эрт илрүүлэг, үзлэг шинжилгээ эхэлж, 2017 оны 06 дугаар сарын 13-ны байдлаар 2785 иргэн буюу 71 хувь нь хамрагдсанаас 305 хүнд В,С вирус илрээд байна. В,С вирус, сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хорт халдврыг илрүүлж бууруулах зорилт, арга хэмжээний хүрээнд ОНХС-аас “Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-өөс 1,5 сая төгрөг зарцуулагдаж байна.	70
17	3.1.8. Хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, оношилгоо,	1	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, амаржих газрын		АЗДТГ	-	Нярай, хүүхдэд зонхилон	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, аймгийн	70

	<p>эмчилгээний тоног төхөөрөмжийг сайжруулахад эхний ээлжинд анхаарна.</p>		<p>нярай, хүүхдийн тусламж, үйлчилгээний чадавхийг нэмэгдүүлж, оношлогоо, эмчилгээний багаж, хэрэгслээр хангах</p>			<p>тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний багаж, хэрэгслээр өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн 25 хувь нь хангагдах</p>	<p>эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд сумдын эрүүл мэндийн төвүүдийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ тусгагдсан.</p> <p>Сумдын орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэх нярай, хүүхдийн тусламж үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн судалгаа, төсвийн задаргааг баталсан.</p> <p>Шивээговь сумын ОНХСангийн 2,4 сая төгрөгөөр сүрьеэ, БЗДХ/ХДХВ-ын эрт илрүүлэг үзлэг шинжилгээг зохион байгуулахаар баталсан.</p> <p>Сүмбэр сумын орон нутгийн хөгжлийн сангийн 10,0 сая төгрөгийн хөрөнгөөр “Энх тус дэм” өрхийн эрүүл мэндийн төв эх, хүүхэд, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээнд шаардлагатай 18 нэр төрлийн 42ш тоног төхөөрөмж, 3 төрлийн 1100 оношлуур, цэрний хайрцаг 522, зүрхний цахилгаан бичлэгийн цаас 10 боодол тус тус нийлүүлэгдсэн.</p> <p>Баянтал сумын орон нутгийн хөгжлийн санд 3.0 сая төгрөг эрт илрүүлэг үзлэг шинжилгээ зохион байгуулахаар баталсан.</p>	
--	--	--	--	--	--	--	--	--

		4	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт эсэн мэнд амаржихуйн сургалтын нэгж байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах		АЗДТГ		Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт жирэмсэн эмэгтэйчүүдийг төрөлтөд бэлтгэх сургалтын нэгж байгуулах бэлтгэл ажлыг хангах	Аймгийн Эрүүл мэндийн газар аймгийн нэгдсэн эмнэлгийн төрөх эмэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх кабинетаар дамжуулан “Эсэн мэнд амаржихуйн” 8 удаагийн сургалтанд 40 иргэнийг хамруулсан. Нэгдсэн эмнэлгийн төрөх эмэгтэйчүүдийн тасаг зөвлөлгөө өгөх кабинет болон хэвтэн эмчлүүлэгсэд бүрт эсэн мэнд амаржихуй сэдвээр тогтмол сургалт хийж байна.	40
		5	"Эх, хүүхдэд ээлтэй эмнэлэг" болох хөдөлгөөнийг эрчимжүүлэх		АЗДТГ		Эх, хүүхдэд ээлтэй эмнэлэг шалгаруулах болзол, магадлан итгэмжлэлийн үзүүлэлтүүд бэлэн болох	Эх, хүүхдэд ээлтэй эмнэлэг шалгаруулах, болзол журам, магадлан итгэмжлэлийн үзүүлэлтүүд төслийн шатандаа орон нутагт хэрэгжүүлэх тушаал, журам Эрүүл мэндийн яамнаас батлагдаж ирээгүй байна.	ҮБ
18	3.1.18. Хөдөөгийн суманд ажиллахаар очсон эмч, мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс хөнгөлөлттэй нөхцөлтэй байр орон сууцаар хангах асуудлыг дэмжинэ.	1	Орон нутагт, ялангуяа сумдын эрүүл мэндийн төвийн эмчийг тогтвор суурьшилтай ажиллаж амьдрахад нутгийн засаг захиргааны байгууллагаас дэмжлэг үзүүлэх,	2017-2020	АЗДТГ		Орон нутгийн эмчийн орон сууцны хангалтын талаарх судалгаа хийж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарах	Өрх, сумдын эрүүл мэндийн төвд ажиллаж буй 51 эмч, мэргэжилтнээс орон сууцны судалгаа хийгдсэн бөгөөд үүнээс орон байраар хангах шаардлагатай 16 албан хаагч байна. 2017 оны хагас жилийн байдлаар сумдад ажиллаж байгаа 9 эмч мэргэжилтнийг орон сууцаар хангасан.	40

			орон байраар хангах						
<p>Тэргүүлэх зорилт №3.2.1. Боловсролын үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, амьдралд нийцтэй болгоно. Хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт суралцах боломжтой болж, сурагчид гэр сургуулийнхаа хооронд нийтийн тээвэрт үнэгүй зорчиж, сургууль 3 ээлжгүй болно. Хөдөөд малчны хүүхэд 6-8 насандаа сонголттойгоор суралцах боломжтой болж, дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулна. Сургуулийг хүн хөгжлийн төв болгоно. Сургууль хүүхдэд мэдлэг, боловсрол, чадвар олгодог төдийгүй эрүүл чийрэг, эерэг зан суртахуун, хүмүүжил, төлөвшилтэй, амьдрах ухаантай, эх оронч, үндэсний бахархалтай хүн болоход нь тусалдаг болно. Бүх шатны боловсролын үйлчилгээний чанар, үр дүнг үнэлэх боломжтой болгож стандартад суурилсан боловсролын тогтолцоог бүрдүүлнэ. Их, дээд сургууль, коллежийн оюутны суралцах эрхийн баталгааг хангаж, өрхийн боловсролын зардлыг бууруулж, дээд боловсролын сургалтын чанарыг дэмжинэ. Оюутанд үндэсний тэтгэлгийг үргэлжлүүлэн олгоно. Оюутан сургалтын төлбөрийн дарамтгүй, эрүүл мэндийн үйлчилгээтэй, суралцах хугацаандаа цагийн ажил эрхлэх, дотуур байранд амьдрах боломжтой болно. Төрийн өмчийн их, дээд сургуулийн бие даасан байдлыг хангаж, дээд боловсролд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд баримжаалсан мэргэжилтэн бэлтгэх, стандартад суурилсан чанарын хяналтын бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлнэ. Бүх шатны боловсрол, сургалтын байгууллагад нийгэм, сэтгэл зүй, дэд бүтцийн эрүүл, аюулгүй, ээлтэй орчин, нийгмийн үйлчилгээг бий болгоно.</p>									
19	3.2.2. “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг хэрэгжүүлж хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгоно.	1	Цэцэрлэг барих төр, орон нутгийн болон олон улсын тусламжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх		АЗДТГ	32,286.0	СӨБ-д хамрагдаагүй хүүхдийн тоо 7 хувиар буурах	Сүмбэр суманд баригдаж байгаа Канад цэцэрлэгийг үргэлжлүүлэн барих хөрөнгө санхүүжилт шийдвэрлэгдээгүй байна. Орон нутгийн зүгээс хамгаалалтын бүс тогтоон, гүйцэтгэгч байгууллага мэргэжлийн байгууллагаар барилгын хийц, үндсэн материалд дүгнэлт гаргуулсан бөгөөд дүгнэлтээр барилгыг яаралтай барьж дуусгах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан байна. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр баригдах цэцэрлэгийн газрыг аймгийн Засаг даргын 2017 оны А/35 дугаар захирамжаар олгосон.	40
		2	Хөдөө орон нутагт малчдын хүүхдэд зориулсан гэр цэцэрлэгийн тоог		АЗДТГ		Жилд 50 гэр цэцэрлэг нийлүүлэх, малчны нийт	Малчдын хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох нүүдлийн бүлгийн сургалтын үйл ажиллагааг	70

			өсгөх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх				1000 хүүхдийг хамруулах	06 дугаар сарын 05-наас 4 цэцэрлэг үйл ажиллагаагаа эхлүүлсэн. 1-р цэцэрлэг "Малх"-д 4 багшийн бүрэлдэхүүнтэй 30 хүүхэд, 2-р цэцэрлэг "Гашуун"-д 4 багшийн бүрэлдэхүүнтэй 25 хүүхэд 5-р цэцэрлэг "Уулзвар"-т 4 багшийн бүрэлдэхүүнтэй 16 хүүхэд, Сүмбэр сумын төвд 3 багш, 1 тогоочтойгоор 20 хүүхэд, нийт 91 хүүхэд цэцэрлэгт хамрагдаад байна.	
20	3.2.3. Анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид шилжүүлнэ.	1	Сургууль, цэцэрлэгийн эрэлт, хэрэгцээ өндөр байгаа хот сууринд хөрөнгө оруулалтыг төвлөрүүлж, сургууль, цэцэрлэг, дотуур байр, спорт заалны барилга шинээр барих, өргөтгөх, засварлах дунд хугацааны төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах		АЗДТГ		3 ээлжийг 40 хувиар бууруулах	Сүмбэр сумын 1-р цэцэрлэгийн хуучин барилгын их засварын ажлын зураг төсвийг АОНХСангийн 3.0 сая төгрөгөөр Эй Эн И И ХХК-аар гүйцэтгүүлэн, хүлээн авч, барилгын засварт шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд хүсэлтийг хүргүүлээд байна. улсын төсвийн 60.0 сая төгрөгөөр Сүмбэр сумын 2-р цэцэрлэгийн цахилгаан, монтажийг засварлах ажлын тендерийг үнэлэх шатанд, Улсын төсвийн 40.0 сая төгрөгөөр Баянтал сумын спорт заалны засварын ажлын гүйцэтгэгчээр Рашбай ХХК шалгарч гэрээ байгуулан ажил эхлэх шатанд байна. Япон улсын "Өвсний үндэс" хөтөлбөрөөс 116.0 сая төгрөгийн	70

							<p>санхүүжилтээр дотуур байрны 2 өрөө болон гадна фасад, 2016-2017 онд АОНХСангийн 116.6 сая төгрөгөөр Илчит сансар ХХК тоглоомын талбай, явган зам, гэрэлтүүлэг, элсний гар бөмбөгийн талбай, сагсны талбай гэх мэт тохижилтын ажлуудыг гүйцэтгүүлэн, улсын комиссоор байнгын ашиглалтад хүлээн авсан. Сүмбэр сумын 1-р сургуулийн биеийн тамирын талбайн зураг төсвийг Эй Эн И И ХХК-аар гүйцэтгүүлж байгаа бөгөөд экспертизээр батлуулах шатанд хийгдэж байна.</p> <p>Мөн улсын төсвийн 75 сая төгрөгийн хөрөнгөөр аймгийн Биеийн тамир спортын газрын засвар, улсын төсвийн 120.0 сая төгрөгийн хөрөнгөөр Усан спорт, сургалтын төвийн засварын ажлуудыг хийхээр тендер шалгаруулалтыг зарлаад байна.</p> <p>Сүмбэр сумын 2-р сургуулийн 640 хүүхдийн шинэ барилгын зураг төсөв боловсруулах ажил хийгдэж байгаа бөгөөд сургуулийн барилгын санхүүжилт, Сүмбэр сумын 100 хүүхдийн Канад загварын цэцэрлэгийн барилгыг үргэлжлүүлэн барих хөрөнгө шийдвэрлэгдээгүй байна.</p>
--	--	--	--	--	--	--	--

21	3.2.6. Сурагчид дотуур байрандаа эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулж, бага ангийн 6-8 настай хүүхдэд зориулсан асаргаа, халамж, хөгжлийн үйлчилгээтэй болгоно.	2	Дотуур байрны орчин, үйлчилгээний нөхцөл байдлын судалгааг гаргаж, дотуур байрыг халуун ус, угаалгын үйлчилгээ, номын сан, чөлөөт цагаа өнгөрүүлэх хүүхэд хөгжлийн танхим, тоглоомын өрөөтэй болгох	2016-2018	АЗДТГ		Дотуур байрны орчин, үйлчилгээний нөхцөл байдлыг сайжруулах	Дотуур байрны орчин, үйлчилгээний нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн дотуур байрыг 2016 оны АОНХСангийн 116.6 сая төгрөгөөр гадна тохижилтын ажлыг 2016-2017 онд хийж байгаа бөгөөд тус ажлын хүрээнд тоглоомын талбай, явган зам, гэрэлтүүлэг, элсний гар бөмбөгийн талбай, сагсан бөмбөгийн талбай хийгдээд байна. Япон улсын Засгийн газрын Өвсний үндэс хөтөлбөрийн 168.0 сая төгрөгөөр номын сан, дотор фитнесийн өрөөг тус тус тохижуулан, улсын комисс байнгын ашиглалтад хүлээн аваад байна.	100
22	3.2.7. Цэцэрлэг, сургуулийн орчин гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, автомашины хурд сааруулагчтай болгоно.	2	Судалгаанд үндэслэн сургуулийн аюулгүй орчныг бүрдүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх	2016-2017	АЗДТГ		Жилд 20 сургуульд замын хөдөлгөөний болон ахуйн осол, бэртэл буурах нөхцөл бүрдэх	Цэцэрлэг, сургуулийн орчныг сайжруулахаар 1 дүгээр сургуулийн гадна биеийн тамирын талбайн тохижилтын зураг төсвийг хийлгэж байна. Мөн аймгийн төвийг камержуулах ажлын хүрээнд төвийн сургууль орчимд камержуулалтын ажил хийгдэхээр туссан. Аймгийн хэмжээнд 3 сургуулийн ойролцоох зам дагуу нийтдээ 4 хурд сааруулагчийг байршуулсан. Аймгийн Цагдаагийн хэлтсийн Замын тасагтай хамтран Замын хөдөлгөөний дүрэм, БСШУССайдын тушаалын дагуу 10	70

							хүртэлх насны хүүхдийг эцэг эхийн гараас гарт хүргэх ажлыг идэвхитэй хамтран зохион байгуулж байна. Уг дүрмийг биелүүлээгүй 2 багшид хариуцлага тооцсон.	
Тэргүүлэх зорилт №3.3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвар, мэргэшилтэй ажилтны тоог нэмэгдүүлэх замаар хүн амын орлогыг дээшлүүлэн дундаж давхаргын хүрээг нэмэгдүүлж, иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулна.								
23	3.3.3 Хүн амын төвлөрлийг сааруулж, бүсчилсэн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого хэрэгжүүлж, орон нутгийн санаачилгыг дэмжинэ.	1	Орон нутгийн онцлогийг тусган боловсруулсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төслийг нутгийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	2016-2020	АЗДТГ	Орон нутгийн байгууллагуу дыг татан оролцуулж, саналыг тусгах	Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2017 оны 03 тогтоолын дагуу “Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот 3 төслийг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлсэн. Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжих хөтөлбөрийн арга хэмжээг эхлүүлэн хэрэгжүүлж байна.	40
Тэргүүлэх зорилт №3.3. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвар, мэргэшилтэй ажилтны тоог нэмэгдүүлэх замаар хүн амын орлогыг дээшлүүлэн дундаж давхаргын хүрээг нэмэгдүүлж, иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулна.								
24	3.3.26. Ахмад настны асаргаа үйлчилгээ, сэргээн засах болон сувилахуйн үйлчилгээг өргөжүүлж, хувийн хэвшлийн асрамжийн газар байгуулахыг дэмжинэ.	3	Сэргээн засах төв, сувилахуйн төв, сувилал, хөнгөвчлөх асаргаа сувилгааны төв байгуулах	2017-2020	АЗДТГ	Эрх зүйн орчин бүрдэх	Ахмад настны асаргаа үйлчилгээ, сэргээн засах болон сувилахуйн үйлчилгээг үзүүлэх талаар хувийн хэвшлийн байгууллага одоогоор санал ирүүлээгүй байна. 2017 оны 05 дугаар сарын 10-нд БНСУ-ын Dei-Jin Их сургуулийн удирдлага, хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл манай аймагт зочилсон. Энэ үеэр манай аймагт тулгамдаж байгаа ахмадын асаргаа сувиллын талаар хамтран	0

							ажиллах санал тавьсан. Цаашид сэргээн засах төв байгуулах талаар төлөвлөн ажиллаж байна.	
25	3.3.28. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого баримтална.	2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн дэд бүтцийн байгууламжид саадгүй хүрэх нөхцөлийг хангах талаар хот, суурины хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын зураг төсөл, барилга байгууламжийн зураг төсөлд тусгуулан хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	2017-2020	АЗДТГ	Хэрэгжилтийг зохион байгуулах	Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх Сүмбэр сумын өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн зураг төсвийг 2.5 сая төгрөгөөр хийлгэж барилгын ажлын төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний дэд бүтцийг тусгасан. ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх аймгийн Нэгдсэн эмнэлгийн их засварын ажилд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг мөн шийдвэрлэхээр тусгасан.	40
Тэргүүлэх зорилт №3.4. Монгол гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, бат бөх хариуцлагатай гэр бүлийг дэмжин, хүүхдийн эрхийг дээдэлж залуучуудыг хөгжих, суралцах, хөдөлмөрлөх таатай орчин нөхцлөөр хангана								
26	3.4.2. Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, хүчирхийллийг бууруулах, хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах, гэр бүлийн гишүүдийн	5	"Хамтарсан баг"-ийн үйл ажиллагааг дэмжиж, хамгааллын тусламж шуурхай үзүүлэх түр	2016-2020	АЗДТГ	Хамтарсан багийн ажиллах журмыг батлуулж, хэрэгжүүлж эхлэх	Сумдын хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийг шинэчлэн байгуулж, хагас жилийн байдлаар хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулах 3 удаагийн сургалт, 1 удаагийн туршлага судлах аяллыг зохион	40

	хариуцлагыг нэмэгдүүлэх эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.		хамгаалах байр байгуулах				байгуулж нийт 5.8 сая төгрөгийг зарцуулаад байна. Манай аймаг “Гэр бүл, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний байр”-тай болсон. Орон нутгийн хөгжил сангийн 6 сая төгрөгөөр “Гэр бүл, хүүхэд хамгааллын байр”-ны тоног төхөөрөмж нийлүүлэх компанийг сонгон шалгаруулж шууд гэрээ байгуулсан. Хуулийн байгууллагуудтай хамтран “Гэр бүл, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний байр”-ны тохижилтод сайн үйлсийн аян зохион байгуулах шийдвэрийг хуулийн байгууллагын удирдлагуудын уулзалтаар шийдвэрлэж үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.	
